



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Баруун сэлбийн гудамж,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltai.gov.mn

2025. 10. 03 № 147-24
танай -ны №

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮҮХЭД
ХӨГЖЛИЙН ЦОГЦОЛБОР УТҮГ-ЫН
ДАРГА Б.БОЛОРТУНГАЛАГ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Дотоод аудитын албаны үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний дагуу Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны 25/23 дугаар “Чингэлтэй дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолбор УТҮГ-ын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- Дүүргийн хүүхэд хөгжлийн цогцолбор УТҮГ-ын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын хэрэгжилт, эрсдэл болон бодлогын баримт бичигт үнэлгээ хийгдээгүй.
- Байгууллагын бизнес төлөвлөгөө боловсруулж батлуулах, гүйцэтгэлийг хангах, үйлчилгээ үзүүлэхдээ үйлчилгээний хөлс, үнэ тарифыг тухайн үеийн зах зээлийн нөхцөл байдлын судалгааг үндэслэн дүүргийн Засаг даргаар батлуулахаар заажээ. Дүрмээр заасан дээрх заалтууд хэрэгжээгүй.
- Ажилтан албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангаагүй.
- Байгууллагын дарга, даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нар тайлант онуудад ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг эрх бүхий албан тушаалтны дүгнэсэн үнэлгээ, шийдвэргүйгээр авсан.
- 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн даргын Б/66 тушаалаар урамшуулалт цалин гэж нийт 16 албан хаагчдад 20,183.0 мянган төгрөгийг илүү олгосон.
- 2024 он, 2025 оны эхний хагас жилд илүү цагийн нэмэгдэл олгохдоо Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй.
- 2024 оны хамт олны 7, 10 дугаар хуралдааны тэмдэглэл, даргын 2024 оны Б/15, Б/16 дугаар буцалтгүй тусламж үзүүлэх тушаалаар 3 ажилтанд буцалтгүй тусламж олгохдоо байгууллагын дотоод журмын холбогдох заалтаас өөр дүнгээр мөнгөн тусламж олгосон.
- Ботгохон явуулын номын сангийн зориулалтаар тоноглогдсон 2014 онд үйлдвэрлэгдсэн Hyundai County маркийн автобусыг өөрийн байгууллагын нэрээр автомашины гэрчилгээ авсан боловч өөрийн дансанд бүртгэж аваагүй.
- Ажилтан албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилийн эхэнд батлуулан ажилласан байх ба 2024 оны эхний саруудад сар бүр тайлагнаж ажилласан бол хагас жилээс хойших зарим саруудын тайлагнал байхгүй, өмнөх жилийн баримтуудыг архивлах ажил хийгдээгүй.

- 2025 оны Зардал гаргах тухай А/35 дугаар тушаалаар орон нутагт хүүхдийн зуслангийн үйл ажиллагаатай танилцахад 2,000.0 мянган төгрөгийн зардал гаргахдаа төсвийн зарцуулалтыг тодорхойлоогүй, зарцуулалтын тайлан үйлдээгүй, баримтыг хавсаргаагүй, томилолт авсан албан тушаал тодорхойгүй.

Иймд Чингэлтэй дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолбор УТҮГ-ын санхүү болон үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллахыг дараах Зөвлөмжөөр хүргүүлж байна.

1. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамж, 2024 онд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", 2025 онд Засгийн газрын 2025 оны 43 дугаар Журам батлах тухай тогтоолоор Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журмын хэрэгжилтийг хангах

2. Чингэлтэй дүүргийн хүүхэд хөгжлийн цогцолбор УТҮГ-ын дүрмийн 4 дэх хэсгийн 4.1-4.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

3. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилтийг хангаж ажиллах

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3. Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" 1.2.1. төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид олгоно гэснийг хэрэгжүүлж ажиллах

5. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" 2.2. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дахь заалтад Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай. гэснийг баримталж ажиллах

6. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах

7. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудтай нийцүүлэн ажиллах

8. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах

9. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг ханган ажиллах

10. Сангийн сайдын 2024 оны “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” А/52 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг бүрдүүлж ажиллах шаардлагатай.

Зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2025 оны 10 дугаар 27-ны өдрийн дотор тус дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 4 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.

ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2025 оны 11 дүгээр сарын 10

№. 26 .

Улаанбаатар хот

2022-2024 оны бохир ус татан зайлуулах зардлын
санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн тухай

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Дотоод аудитын албаны 2025 оны 2/91 дүгээр албан бичиг, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 33 дугаар Мөрдөгчийн мэдэгдэл, дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/12 дугаар “Дүүргийн цэвэр, бохир ус татан зайлуулах зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дэргэдэх байгууллагууд, Хороод, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2022-2024 оны бохир ус татан зайлуулах зардлын санхүүжилт, гүйцэтгэлд дүүргийн Дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

Удирдамжийн дагуу Нийслэлийн хүүхдийн 174 дүгээр цэцэрлэгийн 2022-2024 оны бохир ус татан зайлуулах зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

- Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Журам батлах тухай А/727 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтын ажлууд хийгдээгүй.
- Гэрээний зүйл заалт тодорхой бус гэрээний заалтад зөөвөрлөж буй бохирын хэмжээг тонноор тусгасан боловч зарлага замын хуудсаар м3-ээр тооцсон, машин техникийн мэдээлэл тусгаагүй. Гэрээний хугацаа дуусахад гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй.
- Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй. Тухайлбал бохир соролтын тэмдэглэлд машины улсын бүртгэлийн дугаар сери, даац бичигдээгүй, ирсэн явсан цагийг тэмдэглээгүй, нэг бал нэг гараар бичигдсэн, нийт зөөвөрлөсөн бохирын хэмжээ тодорхойгүй, анхан шатны баримт засвартай. “Жижүүр хүлээлцэх дэвтэр”-ийг бүрэн хөтлөөгүй.
- 2022 онд 44,913.9 мянган төгрөг, 2023 онд 46,490.0 мянган төгрөг, 2024 онд 51,560.0 мянган төгрөгийг бохир ус зайлуулан тээвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн.

- Бохир ус татан зайлуулсан рейс болон жингийн тоо хэмжээ хэт олон байгаа нь тухайн байгууллагын байршил болон хүүхдийн тоотой харьцуулахад үндэслэл муутай.

Бохир ус татан зайлуулах зайлуулах гэрээ, бохир ус татан зөөвөрлөх үйл ажиллагаа, зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллахыг дараах Зөвлөмжөөр хүргүүлж байна.

1. Бохир ус татан зайлуулах гэрээнд гүйцэтгэгч байгууллагын авто машины марк, сери, дугаар өөрийн жин, нийт жин, гэрээний үнийн дүнгийн өөрчлөлтийг тусгаж баталгаажуулах, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, автомашины гэрчилгээ, аж нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулалтыг хавсаргах, гэрээ дуусгавар болоход гэрээний биелэлтийг дүгнэх

2. Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Журам батлах тухай А/727 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Бохир соруулж буй байгууллагын бохир ус татан зайлуулах тэмдэглэл, тооцооны хуудас анхан шатны баримтын бүрдэл, тооцоог сайжруулж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэснийг хэрэгжүүлэх.

4. Бохир ус татан зайлуулсан тайланг сар бүр гаргаж хагас, бүтэн жилээр гүйцэтгэгч байгууллагатай тооцоо нийлж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэснийг бүрэн хэрэгжүүлэх

5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно. Засгийн газрын 2024 оны 2 дугаар Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай тогтоолыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар төлөвлөгөө тайланг 2025 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор тус дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 4 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.

ХЯНАСАН:
ДАРГА

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
ДОТООД АУДИТОР



М.ХОРОЛСҮРЭН

Ц.ДАВААСҮРЭН

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2025 оны 12 дугаар сарын 04

№ 30

Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 39 дүгээр
цэцэрлэгийн 2025 оны цалин хөлс олголт
хяналт шалгалт хийсэн тухай

Нийслэлийн хүүхдийн 39 дүгээр цэцэрлэгийн багш Ц.Энхээгийн өргөдөл, Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны №25/27 дугаар удирдамжийн дагуу Нийслэлийн хүүхдийн 39 дүгээр цэцэрлэгийн 2025 оны цалин хөлс олголт хууль журам, тогтоолын дагуу олгогдож буй эсэхэд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрсэн болно. Үүнд.

1. 7 ажилтны ажилласан хугацааны төрийн албан хаагчийн нэмэгдлийг тооцож олгоогүй.
2. Ажилтнуудын цалинг тооцон олгохдоо анхан шатны баримт болох өдөр бүрийн цагийн бүртгэлд бүртгэгдсэн хоногоос илүү хоногоор тооцон олгосон.
3. Тушаал шийдвэргүйгээр нэмэгдэл хөлс олгосон. /Тусгай хэрэгцээт хүүхэд/
4. Ажилтныг цагаар ажиллуулахаар ажилд авах тушаал гаргасан боловч хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, цалинг тооцон олгохдоо анхан шатны баримтгүйгээр илүү цагийн хөлсөөр тооцон олгосон.
5. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тооцож олгодоггүй өр авлага үүсгэн цалин хөлсийг илүү, дутуу олгодог. Тушаал шийдвэр үг, үсэг, утга агуулгын алдаатай, хавсралт шийдвэрийн огноо дугаартай нийцэхгүй.
6. Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээг багш ажилтны оролцоотойгоор хууль, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулах, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг мөрдүүлэх, шинээр орсон багш ажилтнууд болон арга зүйчийг чадавхжуулах, арга зүй удирдлагаар тогтмол хангах.
7. Ёс зүйн дэд хороо байгуулсан боловч үйл ажиллагаа хийгдээгүй, төлөвлөгөө тайлан байхгүй.
8. 1 ажилтны ажилласан хугацааны мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тооцож олгоогүй зэрэг зөрчил дутагдал байна.

Иймд санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг хүргүүлж байна.

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 20 дугаар зүйлийн 20.1.4. хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;

2. Төсвийн тухай хуулийн 16.5.1-16.5.6 заалтуудыг ханган ажиллах
3. Хууль дүрэм шинэчлэгдэх тухай бүр, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, бусад эрх зүйн акттай уялдуулан шинэчлэх:
4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах

Зөвлөмжийн дагуу зөрчил дутагдалгүй ажилласан, дахин давтан гаргахгүй байх чиглэлээр хийсэн ажлын тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2026 оны 01 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.

ХЯНАСАН:
АЛБАНЫ ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
АХЛАХ ДОТООД АУДИТОР

Х.ОДОНЧИМЭГ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2025 оны 11 дүгээр сарын 10

№ 25

Улаанбаатар хот

2022-2024 оны бохир ус татан зайлуулах зардлын
санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн тухай

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Дотоод аудитын албаны 2025 оны 2/91 дүгээр албан бичиг, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 33 дугаар Мөрдөгчийн мэдэгдэл, дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/12 дугаар “Дүүргийн цэвэр, бохир ус татан зайлуулах зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дэргэдэх байгууллагууд, Хороод, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2022-2024 оны бохир ус татан зайлуулах зардлын санхүүжилт, гүйцэтгэлд дүүргийн Дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

Удирдамжийн дагуу Ерөнхий боловсролын 140 дүгээр сургуулийн 2022-2024 оны бохир ус татан зайлуулах зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

- Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Журам батлах тухай А/727 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтын ажлууд хийгдээгүй.
- 2023-2024 онд бохир ус зайлуулан тээвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн дүн шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн.

Бохир ус татан зайлуулах зайлуулах гэрээ, бохир ус татан зөөвөрлөх үйл ажиллагаа, зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллахыг дараах **Зөвлөмжөөр** хүргүүлж байна.

1. Бохир ус татан зайлуулах гэрээнд гүйцэтгэгч байгууллагын авто машины марк, сери, дугаар өөрийн жин, нийт жин, гэрээний үнийн дүнгийн өөрчлөлтийг тусгаж баталгаажуулах, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, автомашины гэрчилгээ, аж нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулалтыг хавсаргах, гэрээ дуусгавар болоход гэрээний биелэлтийг дүгнэх

2. Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Журам батлах тухай А/727 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Бохир соруулж буй байгууллагын бохир ус татан зайлуулах тэмдэглэл, тооцооны хуудас анхан шатны баримтын бүрдэл, тооцоог сайжруулж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэснийг хэрэгжүүлэх.

4. Бохир ус татан зайлуулсан тайланг сар бүр гаргаж хагас, бүтэн жилээр гүйцэтгэгч байгууллагатай тооцоо нийлж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэснийг бүрэн хэрэгжүүлэх

5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно. Засгийн газрын 2024 оны 2 дугаар Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай тогтоолыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар төлөвлөгөө тайланг 2025 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн дотор тус дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.


Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 4 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.

ХЯНАСАН:
ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
ДОТООД АУДИТОР



Ц.ДАВААСҮРЭН

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2025 оны 11 дүгээр сарын 12

№. ᠘8

Улаанбаатар хот

Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүтээн
байгуулалтын зарим ажлуудын гүйцэтгэлд
хяналт шалгалт хийсэн тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/24 дүгээр удирдамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт Улс, Нийслэл, Дүүргийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 01 дүгээр сараас 09 дүгээр саруудад хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын гүйцэтгэлд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрсэн болно. Үүнд:

- Зарим ажлын нэмэлт гэрээг байгуулахдаа гэрээ дүгнэсэн маягт үйлдээгүй.

- Бараа худалдан авсан гэрээний нэршил оновчтой бус. Тухайлбал: Төлөвлөгөөгөөр 17-р сургуулийн спорт зааланд засвар хийхээр төлөвлөсөн бол гэрээгээр зөвхөн шалны засвар хийхээр гэрээ байгуулсан, 145 дугаар сургуулийн номын сангийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээгээр тавилга, тоног төхөөрөмж нийлүүлсэн.

- Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ нь захиалагчийн хяналт хийх ажлын журмыг шинэчилж боловсруулаагүй.

- Ижил төрлийн адил өртөгтэй хөрөнгийг тендер зарлалгүйгээр төсөвт өртөгийг хувааж шууд худалдан авалт хийсэн. Үүнд: Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэст тоног төхөөрөмж нийлүүлсэн.

- Ахмадын өргөөний тохижилт, засварын ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулж ажилласан боловч Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн 2-р хэлтсийн хэсгийн дэд байрны засварын зураг төсөв нэртэйгээр гарсан нь гэрээ, ажлын зургийн нэршил зөрүүтэй.

- Орон сууцны байшингийн дээвэр, фасадын засварыг хийж байгаа нь хөрөнгө оруулалтын шинж чанаргүй байгаа зэрэг зөрчил дутагдал байна.

Иймд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч цаашид хэрэгжүүлж ажиллах дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам 4.7.9.Төсөл, арга хэмжээний гэрээ дуусгавар болох, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад гэрээ дүгнэсэн актыг энэ журмын 16

дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргах бөгөөд эцсийн санхүүжилтийн хүсэлтэд эх хувиар хавсаргана гэснийг хэрэгжүүлэх

2. Ажил гүйцэтгэх, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний ангиллаар оновчтой төлөвлөх, арга хэмжээг төлөвлөхдөө ажлын нэр, хүчин чадал гэх мэт оноосон нэр, нэршлийг тодорхой бичих

3. Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хийх журмыг шинэчилж боловсруулан батлуулах

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно гэснийг мөрдөж ажиллах


5. Гэрээгээр хүлээсэн эрх үүргийн дагуу бараа, ажил, үйлчилгээний батлагдсан нэрийг солих, өөрчлөхгүй байх, өөрчлөгдсөн тохиолдолд санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх

6. Төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах

Зөвлөмжийн дагуу зөрчил дутагдалгүй ажилласан, дахин давтан гаргахгүй байх чиглэлээр хийсэн ажлын тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2026 оны 1 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.

ХЯНАСАН:
ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
ДОТООД АУДИТОР



Д.АЖМЯНГАН

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2025 оны 11 дүгээр сарын 18

№ 29

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Ахмадын хорооны
санхүүгийн болон үйл ажиллагаанд
дотоод аудит хийсэн тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны №25/22 дугаар удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн Ахмадын хорооны 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрсэн болно. Үүнд:

1. Бүтэц орон тоо батлагдаагүй, цалин хөлс тогтоосон үндэслэл тодорхойгүй.
2. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 19 нэр төрлийн 9,531.2 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй .
3. Эд хариуцагчийн карт хөтөлж үндсэн хөрөнгө бараа материалын бүртгэлд хяналт тавих.

Иймд санхүүгийн болон үйл ажиллагаанд дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах дараах ЗӨВЛӨМЖ хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Монголын ахмадын холбооны дүрмийн 12.11. Ахмадын хорооны ахмадын Бага хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ: 12.11.5. Ахмадын хороо, зөвлөлүүдийн эд хөрөнгийн ашиглалт, төсөв, санхүүгийн асуудал; 12.11.6. Дүрэм, үйл ажиллагааныхаа хүрээнд хамаарах бусад асуудал. Чингэлтэй дүүргийн ахмадын хорооны дүрмийн 10.2 Ахмадын хорооны дарга нь ажлын албатай байх бөгөөд орон тоо, ажилтнуудын цалинг ахмадын хорооны даргын тушаалаар тогтооно
2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 тогтоолын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын

хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалт, Чингэлтэй дүүргийн ахмадын хорооны дүрмийн 9 зүйлийн 9.5 Ахмадын хороонд ашиглаж байгаа эд хогшил, цахим төхөөрөмж болон түргэн элэгдэх эд зүйлсийн ашигласан хугацаа элэгдлийг тооцон жилийн эцэст актлан данснаас хасна.

3. 10. Ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл НХМаягт БМ-10 Аж ахуйн нэгж, байгууллагын ажилчин, албан хаагчдын албан хэрэгцээнд эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэр төрлөөр ангилан бүртгэж, уг бүртгэлийг тооллогын комисс 3 хувь үйлдэж, 1 дүгээр хувийг санхүүгийн албанд, 2 дугаар хувийг аж ахуйн эрхлэгч (нярав)-д, үлдэх хувийг эд хариуцагчид өгнө.

Зөрчил дутагдал арилгасан болон зөвлөмжийн дагуу цаашид хэрэгжүүлэх ажлын тайланг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлнэ үү.

ХЯНАСАН:
АЛБАНЫ ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН
ДОТООД АУДИТОР

Г.БАЯРМАА

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2025 оны 12 дугаар сарын 08

№ 32

Улаанбаатар хот

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд
нийцлийн аудит хийсэн тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн №25/28 дугаар удирдамжийн дагуу улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагын хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах зорилготойгоор гаргасан Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахын тулд хууль, журмын хэрэгжилтэд нийцлийн аудит хийлээ.

Тус аудитаар дүүргийн Теле камерын хяналтын дэд төв ОНӨТҮГ-ын шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 2025 оны 1-11 дүгээр сард байршуулсан мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан байдал, мэдээллийн иж бүрэн байдал, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийж Шилэн дансны тухай хуулийн зарим зүйл, заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлүүд илэрснийг залруулж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Үүнд:

- Байгууллагын батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төслийн мэдээлэл байршуулаагүй.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш төгрөгийн 6 сарын мэдээлэл, 6 гүйлгээний 114,114.3 мянган төгрөгийн үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг байршуулаагүй.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш төгрөгийн 6 сарын мэдээлэл, 3 гүйлгээний 166,389.5 мянган төгрөгийн үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг байршуулаагүй.
- Тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлтийн мэдээлэл байршуулаагүй.
- Тухайн жилийн баталгаажсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулаагүй.
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээний 13 байгууллагын 157,301.7 мянган төгрөгийн ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг байршуулаагүй.

- Байгууллагын даргын 142,111.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардал гаргасан 14 тушаалыг байршуулаагүй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллахыг дараах **ЗӨВЛӨМЖ**өөр хүргүүлж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлэх

2. Шилэн дансны тухай хуулийн 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах

3. Шилэн дансны тухай хуулийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр үнэн зөвөөр мэдээлэх

4. Энэ хуулийн 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг мэдээлэх

5. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах

6. Шилэн дансны тухай хуулийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг байршуулах

7. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн оруулах.

Зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөө, тайланг 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

ХЯНАСАН:
ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
ДОТООД АУДИТОР

В.ХАВААСҮРЭН Ц.ДАВААСҮРЭН

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2025 оны 12 дугаар сарын 08

№...31

Улаанбаатар хот

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд
нийцлийн аудит хийсэн тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн №25/28 дугаар удирдамжийн дагуу улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагын хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах зорилготойгоор гаргасан Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахын тулд хууль, журмын хэрэгжилтэд нийцлийн аудит хийсэн.

Тус аудитаар дүүргийн Хоймор хайрхан амралт ОНӨТҮГ-ын шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 2025 оны 1-11 дүгээр сард байршуулсан мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан байдал, мэдээллийн иж бүрэн байдал, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийж Шилэн дансны тухай хуулийн зарим зүйл, заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлүүд илэрснийг залруулж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт эдийн засгийн ангиллыг байршуулахдаа зарим сарын мэдээллийг хоцроосон, байршуулаагүй, тайлбар бичээгүй байсан ба дотоод аудит хийх хугацаанд нөхөн байршуулж залруулсан.

- Санхүүгийн тайлан /хагас жилийн/ мэдээллийг тогтоосон хугацаанд байршуулаагүй хоцроосон.

- Байгууллагын батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төслийн мэдээлэл хоцроосон.

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг дутуу байршуулсан, үйл ажиллагааны орлого байршуулаагүй байсан ба дотоод аудит хийх хугацаанд нөхөн байршуулсан.

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээний мөнгөн дүн, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг байршуулаагүй байсан ба дотоод аудит хийх хугацаанд нөхөн байршуулсан.

- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл 1-12 сарын мэдээлэл дутуу байсан ба дотоод аудит хийх хугацаанд нөхөн байршуулсан.

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хоцорсон төлөвтэй боловч мэдээлэл байршуулаагүй байсан ба нөхөн байршуулсан.

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл дутуу, буруу мэдээлэл байршуулсан байсныг дотоод аудит хийх хугацаанд залруулсан.

- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг дутуу байршуулсан байсныг дотоод аудит хийх хугацаанд нөхөн байршуулсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллахыг дараах **ЗӨВЛӨМЖ**-өөр хүргүүлж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр хугацаанд нь бүрэн байршуулах

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор тогтоосон хугацаанд мэдээлэх

3. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хуулийн хугацаанд байршуулах

4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг тогтоосон хугацаанд бүрэн мэдээлэх

5. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тогтоосон хугацаанд нь өссөн дүнгээр бүрэн байршуулж мэдээлэх

6. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг өөрчлөлт орсон тохиолдолд хуулийн хугацаанд үнэн зөв дэлгэрэнгүй байдлаар мэдээлэх

7. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан

асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор гэснийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаанд нь байршуулах


8. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10. Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна гэснийг хэрэгжүүлэх

9. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн хуулбарыг тогтоосон хугацаанд бүрэн байршуулах

10. Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-д заасан мэдээлэл, хугацааны талаар уншиж судлах

Зөвлөмжийн дагуу 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, тухайн хугацаанд хийсэн ажлын тайланг 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

ХЯНАСАН: ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН

БИЧСЭН: ДОТООД АУДИТОР

ДАХМЯНГАН



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА**

Баруун сэлбийн гудамж,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050

Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

2025.10.23

25

танай

-ны №

Зөвлөмж хүргүүлэх тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/25 дугаартай удирдамжийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын гүйцэтгэл, ашиглалт, хамгаалалтад хяналт шалгалт хийхэд дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

1. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх 16 төсөл арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй, 11 төсөл арга хэмжээний зураг төсөв хийгдээгүй,

2. Захиалагчийн хяналтын байгууллага нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Нийслэлийн 56 болон 173 дугаар цэцэрлэгийн дээвэр фасад засварлах ажилд хяналт тавихдаа ажлын тоо хэмжээ, үе шат бүрээр хяналтыг тавиагүй,

3. Захиалагч нь захиалагчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагатай хийсэн гэрээний дагуу хяналтыг бүрэн хэрэгжүүлдэггүй,

4. Тендерт шалгарсан Бронзе скай ХХК болон Флейм фүүл энерги ХХК-ний гүйцэтгэсэн дээвэр фасад засварын ажлын гэрээний хугацааг үндэслэлгүй сунгасан.

Иймд цаашид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлбэл зохих дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг хүргүүлж байна.

1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Захиалагчийн хяналт хийж байгаа байгууллага нь 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан "Захиалагчийн хяналт хийх гэрээ"-ний 4.4 дэх заалтыг хэрэгжүүлсэн эсэхэд захиалагч байгууллага хяналт тавьж, ашиглагч байгууллагатай холбоотой ажиллах;

3. Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах.

Зөвлөмжийн дагуу зөрчил дутагдал арилгасан талаар 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 1 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.

АЛБАНЫ ДАРГА



М.ХОРОЛСҮРЭН



НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН
39 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГТ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

2025.12.04 № 41-03/67

Зөрчил арилгуулах тухай

Нийслэлийн хүүхдийн 39 дүгээр цэцэрлэгийн багш Ц.Энхээгийн иргэдөл гомдлын дагуу Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/27 дугаар удирдамжаар Нийслэлийн хүүхдийн 39 дүгээр цэцэрлэгийн 2025 оны цалин хөлс олголт хууль, тогтоол, журмын дагуу олгогдсон эсэхэд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтныг цагаар ажиллуулахаар ажилд авах тушаал гаргасан боловч хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, цалинг тооцон олгоходоо анхан шатны баримтгүйгээр илүү цагийн хөлсөөр тооцон 1,164.8 мянган төгрөгийг зөрүүтэй олгосон байна.

Иймд илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 7.5 хэсгийг үндэслэн **ШААРДАХ** нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх" хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагын дагуу цаашид авч хэрэгжүүлэх болон хэрэгжүүлсэн ажлын тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор албан бичгээр дүүргийн Дотоод аудитын албанд ирүүлнэ үү.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЯАХ БАЙЦААГЧ
М.ХОРОЛСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ
Г.БАЯРМАА

ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН 39 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ

Ц.ДЭЛГЭРМАА

НЯГТЛАН БОДОГЧ

Ц.УРТЖАРГАЛ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА**

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 140 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.СЭЛЭНГЭ ТАНАА**

2025.11.10 № 41-02/64.

Зөрчил арилгуулах тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/12 дугаар "Дүүргийн цэвэр, бохир ус татан зайлуулах зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийх удирдамж"-ийн дагуу танай байгууллагын 2022-2024 оны бохир ус татан зайлуулсан зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Бохир татан зайлуулсан тэмдэглэл тооцооны хуудас, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.
2. Плимут сириус ХХК-тай 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 12 дугаартай байгуулсан гэрээ нь 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 02/22 дугаартай гэрээтэй мөн Ашид эрүүл хөрс ХХК-ний 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 05/2024 дугаартай гэрээтэй хугацааны хувьд давхардсан. Гэрээний биелэлтийг дүгнэж акт үйлдээгүй.

Иймд илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах, цаашид зөрчил гаргуулахгүй байх зорилгоор Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 7.5 хэсгийг үндэслэн ШААРДАХ нь:

1. Бохир соруулж буй байгууллагын бохир ус татан зайлуулах тэмдэглэл, тооцооны хуудас анхан шатны баримтын бүрдэл, тооцоог сайжруулж ажил гүйцэтгэсэн зарлагын баримтад тоо, хэмжээг үнэн зөв бичиж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажиллах. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг хэрэгжүүлэх.
2. Захиргааны ерөнхий хуулийн 52.1.Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно.52.2.2.захиргааны байгууллага

1525020138

өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэх харилцаанд;
Иргэний хуулийн 343 дугаар зүйл, заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагын дагуу цаашид авч
хэрэгжүүлэх болон хэрэгжүүлсэн ажлын тайланг 2025 оны 12 дугаар сарын 10-ний
өдрийн дотор албан бичгээр дүүргийн Дотоод аудитын албанд ирүүлнэ үү.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ


М.ХОРОЛСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ


Ц.ДАВААСҮРЭН

ХҮЛЭЭН АВСАН:
140 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ

НЯГТЛАН БОДОГЧ


Ц.СЭЛЭНГЭ

Ч.ДАВААЖАРГАЛ



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
АХМАДЫН ХОРООНД

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

2025.11.27 № 41-03/66

Зөрчил арилгуулах тухай

Манай алба нь Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/13 удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн Ахмадын хорооны 2024, 2025 оны хагас жилийн санхүү болон үйл ажиллагаа түүнтэй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийлээ.

Тус хяналт шалгалтаар Нягтлан бодогчоор ажиллаж байсан Н.Амаржаргалд Ахмадын хорооны даргын Б/18 тушаалаар 2022-2023 оны тайлангын урамшуулал 2 сарын үндсэн цалинтай тэнцэх урамшуулал олгосон. Өргөдлийн цохолгод 6 сарын буцалтгүй тусламж олгохоор тусгагдсан боловч давхар тушаал гаргуулж авсан

Иймд Ахмадын хорооны 2024, 2025 оны хагас жилийн санхүү болон үйл ажиллагаа түүнтэй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах дараах **АЛБАН ШААРДЛАГА** хүргүүлж байна

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", 20.2.13. "эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах" заалтуудыг мөрдөж ажиллах
- Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагын дагуу цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, биелэлтийг 2025 оны 12 сарын 10-ны дотор албан бичгээр ирүүлнэ үү

АЛБАН ШААРДЛАГЫГ:

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

М.ХОРОЛСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Г.БАЯРМАА

ЗӨВШӨӨРСӨН:

АХМАДЫН ХОРООНЫ ДАРГА

П.ТӨВСАНАА

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ЗУЛ

E:\Documents\2025 ажил\Ахмадын хороо\A.SH.docx

1525020089



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮҮХЭД
ХӨГЖЛИЙН ЦОГЦОЛБОР УТУГ-ЫН
ДАРГА Б.БОЛОРТУНГАЛАГ ТАНАА

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА**

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltel.gov.mn

2025.10.03 № 41-02/63

Зөрчил арилгуулах тухай

Дотоод аудитын албаны үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний дагуу Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны 25/23 дугаар "Чингэлтэй дүүргийн хүүхэд хөгжлийн цогцолбор УТУГ-ын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. Стратеги төлөвлөгөө боловсруулахад зөвлөх үйлчилгээний сугалтыг 2025 оны 05 сард Ай Ти Ай консалтинг ХХК-тай 25/06 дугаартай гэрээ байгуулан нийт ажилчдыг хамруулан зохион байгуулж 6,500.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч 2025 оны 9 дүгээр сарын байдлаар байгууллагын стратеги төлөвлөгөө батлагдаагүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

2. Даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Зардал гаргах тухай А/20 дугаар тушаалаар байгууллагын архивын нөхөн баяжуулалт хийж хүлээлгэж өгөх ажилд зөвлөх үйлчилгээг авахаар 2,000.0 мянган төгрөгийг төсөвлөж зарцуулсан хэдий ч 2016-2023 оны архивын баримтуудыг стандартын дагуу хадгаламжийн нэгж болгон үдэх, хадгаламжийн нэгжийн хугацаагаар ангилж данс бүртгэлийг үйлдэх ажлын гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Иймд илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах, цаашид зөрчил гаргуулахгүй байх зорилгоор Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 7.5 хэсгийг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг хэрэгжүүлэх.

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагын дагуу цаашид авч хэрэгжүүлэх болон хэрэгжүүлсэн ажлын тайланг 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн дотор албан бичгээр дүүргийн Дотоод аудитын албанд ирүүлнэ үү.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

М.ХОРОЛСҮРЭН

Ц.ДАВААСҮРЭН

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН
ЦОГЦОЛБОР УТУГ-ЫН ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

Б.БОЛОРТУНГАЛАГ

Э.АНХТУЯА

D:\Bolor\2025 alban shaardlaga tusul.docx

1525020177